



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ

Аудитыг Монгол улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын 2017 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

АУДИТЫН НЭР: Замын сангийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга, хэмжээний хуваарилалт, зарцуулалт, үр дүн

АУДИТЫН КОД: БАГ-/2017/03-ГА



Баянхонгор хот
2017.04.20

АГУУЛГА

Бүлэг-1. Авто замын санд төвлөрөх хөрөнгийг бодитой тооцож төлөвлөн, бүрэн бүрдүүлсэн эсэх

Бүлэг 2. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, батлуулан санхүүжүүлсэн эсэх

Бүлэг-3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх

Бүлэг-4. Төсөл, арга хэмжээ үр нөлөөтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх

2017 оны 6-р сарын 13

Тайланг:Аймгийн аудитын газрын

Цахим хуудаснаас үзнэ үү:

www.audit.bayankhongor.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442584, 70442424 дугаарын утсаар харилцана уу.

ХАЯГ: Үндэсний аудитын газрын харьяа Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....3

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН.....4

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН6

А. Авто замын санд АТБӨЯХ-ын албан татвар болон замын хураамжийг бодитой төлөвлөөгүйгээс орлогыг бүрэн бүрдүүлж чадахгүй байна.6

Б. Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөлтийг үндэслэлтэй боловсруулсан хэдий ч Засгийн газрын 1998 оны 149-р тогтоолоор батлагдсан журмын 8-д “орон нутгийн замын сангийн хөрөнгийн хэмжээ, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална” гэсэн заалтыг зөрчин аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар баталгаажуулсан байна.7

В. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг журмын дагуу зохион байгуулж байгаа боловч зориулалтын машин, техник, тоног төхөөрөмж хангалтгүй зарим компанийг шалгаруулж, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12-р зүйлийг зөрчжээ.7

Г. Баянхонгор сумын 2,3,7,9-р багийн хатуу хучилттай болон хөрсөн замд үерийн улмаас үүссэн эвдрэл гэмтлийг засварлах ажил дуусаагүй, харин бусад замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлын хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт нь үр нөлөөгөө өгсөн байна.7

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	- ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ГА	- ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ
ИТХ	- ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
ЗДТГ	- ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
АЗДТГ	- АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ТЭЗҮ	- ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ
ХХК	- ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
АТБӨЯХАТ	- АВТОТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ

ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАР

ТБОНӨХБАҮХАТХ - ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

1.Аудитын нэр: Замын сангийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга, хэмжээний хуваарилалт, зарцуулалт, үр дүн

2.Аудитын код: БАГ-/2017/03-ГА

3.Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 09 дүгээр сарын 13-ний өдрийн 1а/399 тоот албан бичгээр ирүүлсэн аудит хийлгэх захиалга, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/12 дугаар тушаалаар батлагдсан ҮАГ-аас 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

4.Аудитын зорилтууд:

Замын сангийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, бүрдүүлэлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийв.Үүнд:

- Авто замын санд төвлөрөх хөрөнгийг бодитой тооцож төлөвлөн, бүрэн бүрдүүлсэн эсэх
- Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, батлуулан санхүүжүүлсэн эсэх
- Төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх
- Төсөл, арга хэмжээ үр нөлөөтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх

5.Аудитын хамарсан хүрээ:

Аудитаар автозамын сангийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэл, зарцуулалтыг холбогдох байгууллагуудыг хамруулан гүйцэтгэв.

6. Үндсэн мэдээлэл:

2016 онд замын сангийн хөрөнгөөр 25 төсөл арга хэмжээнд 540.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр аймгийн ИТХ-аар төсөв батлагдаж, 541.6 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

7.Эрсдэлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн явцад цуглуулж судалсан баримт, материал, урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн, хийх аудитын ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэлэв

8. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамжийн хүрээнд аймгийн ЗДТГ, Орон нутгийн өмчийн газар, ГХБХБГ-ын албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга авч, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

9. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам"
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам."
- Сангийн сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайдын 2000 оны 47/81 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Орон нутгийн замын сангийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх авто зам, замын байгууламжийн ажлыг гүйцэтгэх, хянаж, санхүүжүүлэх журам"
- Холбогдох бусад эрхийн актууд
- Автозамын тухай хууль

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

Авто замын сангийн дансанд 2016 оны эхэнд 142.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд АТБӨЯХАТатвараар орсон 359.8 сая төгрөгийн орлогоос 260.0 сая төгрөгийг, авто замын хураамжаас 100.2 сая төгрөг, нийт 502.8 сая төгрөг төвлөрүүлж, 481.8 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 21.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. АТБӨЯХАТатварын үлдэгдэл 99.8 сая төгрөг аймгийн Ерөнхий орлогын дансанд үлджээ.

А. Авто замын санд АТБӨЯХ-ын албан татвар болон замын хураамжийг бодитой төлөвлөөгүйгээс орлогыг бүрэн бүрдүүлж чадахгүй байна.

А1. Авто замын санд төвлөрүүлэх АТБӨЯХ-ын албан татвар болон замын хураамжийн орлогыг Баянхонгор аймгийн Авто тээврийн газарт бүртгэлтэй автомашины тоотой уялдуулж төлөвлөөгүй байна.

Авто замын санд 2016 онд 320.0 сая төгрөгийг авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслэлийн татварын орлогоос бүрдүүлэхээр аймгийн ИТХ-аар баталсан байна.

Автотээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогыг үндэслэлтэй төлөвлөсөн эсэхийг Баянхонгор аймгийн Авто тээврийн газраас ирүүлсэн авто тээврийн хэрэгслийн тоог аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн төлөвлөсөн тоо болон төвлөрсөн орлогын гүйцэтгэлтэй харьцуулан үзэхэд дараах байдалтай байна.

№	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төрөл	Жилд ногдуулах албан татварын хэмжээ /төгрөгөөр /	Баянхонгор аймгийн Автотээврийн төв		Авто тээврийн дүнд эзлэх хувь	Баянхонгор аймгийн Автотээврийн төв		СТСХ төлөвлөж байгаа		Баянхонгор аймгийн татварын хэлтэс		
			тоо	орлого /мян.төг/		Хасалт хийх 2490 АБӨЯТ хассан тоо	орлого /мян.төг/	тоо	орлого /мян.төг/	тоо	орлого /мян.төг/	
1	2 дугуйтай мотоцикл	2500	5858	14,645.0	28.8	1,141	2,851.3	1967	4917.5	1380	3,450.0	
2	3 дугуйтай мотоцикл	3000		0	-	-	-		0		-	
3	Суудлын авто машин	2001 см3 хүртэл	18	7607	205,389.0	37.4	6,675	180,233.5	2243	48448.8	3930	141,509.0
		2001-3001 см3 хүртэл	20	1404	56,188.1	6.9	1,232	49,306.3	2006	48184.1	2183	120,100.0
		3001 см3 болон түүнээс дээш	28	671	56,382.8	3.3	589	49,477.2	292	17996	265	29,241.0
4	Микроавтобус /15 хүртэл суудалтай	40000	593	23,720.0	2.9	520	20,814.8	438	17520	115	4,210.0	
5	Автобус	60000	56	3,360.0	0.3	49	2,948.5	16	960	27	1,500.0	
6	Ачааны авто машин	1 хүртэл тн-ийн даацтай	25000	-	-	-	-		0	755	18,970.0	
		1-2 тн-ийн даацтай	35000	2879	100,765.0	14.2	2,526	88,423.6	0	427	14,950.0	
		2-3 тн-ийн даацтай	45000		-	-	-	-	0	230	10,290.0	
		3-5 тн-ийн даацтай	55000		-	-	-	-	0	44	2,460.0	
		5-8 тн-ийн даацтай	90000	951	85,590.0	4.7	835	75,107.2	0	50	4,501.0	
		8-10 тн-ийн даацтай	100000		-	-	-	-	1653	165300	17	1,720.0
		10-20 тн-ийн даацтай	110000		-	-	-	-	0	20	2,120.0	
		20-30 тн-ийн даацтай	165000		-	-	-	-	0		-	
		30-40 тн-ийн даацтай	220000		-	-	-	-	0		-	
		40-50 тн-ийн даацтай	280000		-	-	-	-	0		-	
		50-60 тн-ийн даацтай	320000		-	-	-	-	0		-	
		60-70 тн-ийн даацтай	400000		-	-	-	-	0		-	
		70-80 тн-ийн даацтай	420000		-	-	-	-	0		-	
		80-90 тн-ийн даацтай	480000		-	-	-	-	0		-	
90-100 тн-ийн даацтай	500000		-	-	-	-	0		-			
	100 тн-оос дээш	550000		-	-	-	-	0	2	1,200.0		
7	Тусгай зориулалтын авто машин	22500	154	3,465.0	0.8	135	3,040.6	290	6525	23	520.0	
8	Трактор, өөрөө явагч хэрэгсэл	14000	31	434.0	0.2	27	380.8		0		-	
9	Бага оврын трактор	7000		-	-	-	-		0	25	350.0	
10	Чиргүүл /даацын 1 тн тутамд/	7000	110	4,396.0	0.5	97	3,378.5	47	329	18	2,550.0	
	Нийт		20,314.0	554,334.9		13,826.0	475,962.4	8,952.0	310,180.4	9,511.0	359,641.0	

Татварын ерөнхий газрын 2015.12.14-ний өдрийн Авто тээврийн үндэсний төвд ирүүлсэн 2а/3445 тоот албан бичигт “Танай газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу сүүлийн 4 жилд техникийн үзлэгт хамрагдаагүй, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, АТБӨЯХАТ төлөөгүй нийт 95770 тээврийн хэрэгслийг судлан үзэхэд эдгээр тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасахад татгалзах зүйлгүй болно” гэж ирүүлжээ. Үүний дагуу Баянхонгор аймгийн Авто тээврийн газар дээрх 95770 тээврийн хэрэгслээс шүүлт хийж үзэхэд 2488 ширхэг тээврийн хэрэгсэл нь манай аймгийн харьяалалтай тээврийн хэрэгсэл байжээ. Иймд Баянхонгор аймгийн Авто тээврийн газраас тухайн 2488 тээврийн хэрэгслийн жагсаалтыг гаргуулан авав.

Авто тээврийн газраас ирүүлсэн нийт бүртгэлтэй авто машины судалгаанд үндэслэн дээрх 2488 тээврийн хэрэгслийг хувь тэнцүүлэн хасч, мөн 5858 мотоциклоос 2016 онд 1063 ширхэг мотоцикл үзлэгээр орсон ба зөрүү 4795 мотоциклоос 4000 мотоцикл хасч /Энэ нь малчид мотоциклийг үзлэгээр оруулахгүй ихээр задалж сэлбэгэнд хэрэглэдэгтэй холбоотой/ тооцоо хийж үзэхэд аймгийн хэмжээнд нийт 13826 тээврийн хэрэгсэл татвар төлөхөөр байгаа бөгөөд аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 46 дугаар тогтоолоор баталсан татварын хувь хэмжээний интервалын хамгийн бага утгаар орлогыг тооцоход 476.0 сая төгрөг төвлөрөх боломжтой байна. Энэ нь аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн төлөвлөж байгаагаас 4874 тээврийн хэрэгслээр буюу 166.8 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь АБӨЯХ-ийн татвараар орох орлогыг тээврийн хэрэгслийн бодит тоонд уялдуулаагүй төлөвлөжээ.

Мөн авто зам ашигласны төлбөрийн хураамжийн хэмжээг аймгийн Засаг даргын 2014 оны 671 тоот захирамжаар тогтоосон байна. Санхүү төрийн сангийн хэлтэс нь авто зам ашигласны хураамжийн орлогыг төлөвлөхдөө тогтоолд заасан ангиллаар бодит тоо, болон тарифаар төлөвлөдөггүй, өмнөх оны гүйцэтгэлийг суурь болгон авч

№	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төрөл	Жилд ногдуулах хураамж /төгрөгөөр/	Зам ашигласны хураамж	
			Хасалт хийх 2490 АБӨЯТ хассан тоо	орлого /мян.төг/
1	2 дугуйтай мотоцикл	2000	1,141.0	2,282.0
3	Суудлын авто машин	2001 см3 хүртэл	10000	6,675.0
	2001-3001 см3 хүртэл	10000	1,232.0	12,320.0
	3001 см3 болон түүнээс дээш	10000	589.0	5,890.0
4	Микроавтобус /15 хүртэл суудалтай	30000	520.0	15,600.0
5	Автобус	40000	49.0	1,960.0
6	Ачааны авто	1-2 тн-ийн даацтай	20000	2,526.0
	5-8 тн-ийн даацтай	45000	835.0	37,575.0
7	Тусгай зориулалтын авто машин	45000	135.0	6,075.0
8	Трактор, өөрөө явагч хэрэгсэл	50000	27.0	1,350.0
10	Чиргүүл /даацын 1 тн тутамд/ тн-оор	0	97.0	-
Нийт			13,826.0	200,322.0

төлвлөж байна.

Авто тээврийн газраас ирүүлсэн судалгааг үндэслэн дээрх захирамжаар батлагдсан тарифаар авто зам ашигласны хураамжийг тооцож үзэхэд 200.3 сая төгрөгийн орлого төвлөрөх боломжтой байхад 2016 онд 90.0 сая төгрөг орохоор төлөвлөж,

гүйцэтгэлээр 100.2 сая төгрөг орсон байгаа нь 100.1 сая төгрөгийг хурааж аваагүй зам ашигласны хураамжийг дутуу бүрдүүлсэн байна.

Иймд АБӨЯХ-ийн бодит тоо, бүртгэлийг аймгийн Авто тээврийн газартай тохируулж, түүнд үндэслэн төлөвлөлтийг үнэн зөв, бодитой хийхийг аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэст зөвлөмжөөр хүргүүлэв.

А.2 Автозамын сангийн хөрөнгийг АБӨЯХАТ болон авто зам ашигласны хураамжийн орлогоос бүрдүүлсэн байна.

Орон нутгийн авто замын сангийн эх үүсвэрийг Авто замын тухай хуулиар АТӨЯ хэрэгслийн албан татвар, Орон нутгийн зам ашигласны төлбөр, Улсын болон орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгө, Хууль зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийн хувь хэмжээ, Зээл, тусламж, хандивын орлого гэсэн 5 эх үүсвэрээс бүрдүүлэхээр заасан байна.

2016 онд авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар /цаашид АТӨЯХАТ гэх/ -аар 320.0 сая төгрөгийг оруулахаар төлөвлөснөөс 359.6 сая төгрөг төвлөрч төлөвлөгөөг 112,4 хувиар биелүүлсэн ба үүнээс замын санд 260.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Харин зам ашигласны хураамжийн орлогыг 90.0 сая төгрөгөөр төлөвлөж, 100.2 сая төгрөгөөр буюу 111.3 хувиар биелүүлж, орлогыг Замын санд бүрэн төвлөрүүлжээ.

Б. Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөлтийг үндэслэлтэй боловсруулсан хэдий ч Засгийн газрын 1998 оны 149-р тогтоолоор батлагдсан журмын 8-д “орон нутгийн замын сангийн хөрөнгийн хэмжээ, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална” гэсэн заалтыг зөрчин аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар баталгаажуулсан байна.

Б.1 Замын сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг нэгдсэн бодлого, төлөвлөлтийн арга зүй, урт болон дунд хугацааны хөтөлбөрт үндэслэж төлөвлөсөн байна.

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын 2012-2016 оны мөрийн хөтөлбөрийн 1.4.2, 1.4.3, 1.4.5 дахь заалт, Баянхонгор аймгийн нийгэм эдийн засгийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтын 7.1, 7.2, 7.5-д заасан урт болон дунд хугацааны хөтөлбөр, нэгдсэн бодлого, төлөвлөлтийн арга зүйн

дагуу Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 4-р сарын 4-ний өдрийн хуралдаанаар Баянхонгор аймагт 2016 онд замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын жагсаалт, зарцуулах төсвийн хэмжээг хэлэлцэж, шинээр гүйцэтгэх 16 ажилд 320,0 сая төгрөг, өмнөх онд хэрэгжсэн боловч санхүүжилт дутуу олгогдсон 5 ажилд 21,5 сая төгрөг зарцуулахаар шийдвэрлэж, ИТХТ-ийн 25-р тогтоолоор баталгаажуулжээ. Тайлант жилийн хугацаанд дээрх тогтоолд 4 удаа өөрчлөлт оруулжээ.

д.д	Гүйцэтгэх ажлын нэр	Анхны батлагдсан төсөв			Нэмэгдсэн, хасагдсан	Тодотгосон эцсийн төсөв
		тоо хэмжээ	нийт төсөвт өртөг	Замын сангаас анхүүжих		
1	Хот хооронд зорчигч тээврийн нэгдсэн автозогсоол	1200м2	38,828,568	28,828.7	1,000.0	29,828.7
2	Загийн голын модон гүүр	82	45,147,107	30,000.0	-	30,000.0
3	Автозамын тухай хуулийн 18.5 заалт хяналтын зардал		10,461,133	10,461.1	-	10,461.1
4	Гэрлэн дохио хяналтын камерийн 2015 цахилгааны төлбөр		1,264,000	1,264.0	-	1,264.0
5	Гэрлэн дохио хяналтын камерийн 2016 цахилгааны төлбөр		1,500,000	1,500.0	-	1,500.0
6	Хотын төвийн гэрэлтүүлэг	85	27,200,000	17,200.0	-	17,200.0
7	Автозамын зорчих хэсгийн тэмдэглэгээ хийх	500м2, 25ш	14,946,718	14,946.7	-	14,946.7
8	Хөх толгойн дундуур замын зураг төсөв		23,060,804	13,060.8	-	13,060.8
9	Эрдэнэмандал сургуулийн автозогсоол	792м2	23,652,042	23,666.7	-	23,666.7
10	Аймгийн төвийн хатуу хучилттай замын засвар автобусны 2 буудал	1270м2	70,370,700	-	68,144.6	68,144.6
11	19, 25-р байрны авто зогсоол	1520м2	45,600,000	35,600.0	-	35,600.0
12	Автогредерээр шуудуу сэргээж, зам засах	10000м2, 720м3	7,472,047	7,472.0	-	7,472.0
13	ХААНБанк, ҮЭ-ийн өмнөх зогсоолыг шинэчлэх	1320м2	10,000,000	10,000.0	-	10,000.0
14	Номундалай сургуулийн урдуурх автозам	1547м2	50,277,500	40,000.0	-	40,000.0
15	ОНХСанд		60,000,000	60,000.0	-	60,000.0
16	Албан журмын даатгалын холбоонд		26,000,000	26,000.0	2,500.0	28,500.0
17	Төв захын арын замын өргөтгөл, өмнөх автомашины зогсоол				66,593.1	66,593.1
18	Хандиваар баригдах цэцэрлэг гаднах зогсоол				13,987.8	13,987.8
19	Цагаан хөтөлийн Цагдаагийн постны гэрлийн төлбөр 2014-2015				1,843.9	1,843.9
20	Цагаан хөтөлийн Цагдаагийн постны гэрлийн төлбөр 2016				5,072.9	5,072.9
21	13-р цэцэрлэгийн гаднах зогсоол				9,787.7	9,787.7
22	Явган замын засвар				-	
23	БХР 2,3,7,9-р багийн хатуу хучилттай болон хөрсөн замын үерийн улмаас үүссэн эвдрэл, гэмтлийг засварлах				26,978.5	26,978.5
24	Эрдэнэцогт сумын Өвгөнжаргалант Хүрэмтийн гүүрний засвар				2,000.0	2,000.0
25	ҮЭ-ийн өмнөх талбай				9,000.0	9,000.0
26	Анар худалдааны төвийн өмнөх тайлбай				5,000.0	5,000.0
	2016 оны дүн		455,780,619	320,000.0	211,908.5	531,908.5
1	Хотын доторхи авто замын гэрэлтүүлгийн засвар		19,000,000	9,500		9,500.0
2	Эрдэнэцогт сумын Ямаан ус орчмын хайрган замын засвар		10,000,000	1,300		1,300.0
3	Аймгийн ЗДТГ-ын авто зогсоол		6,053,812	1,200		1,200.0
4	Баацагаан сумын Бунхан сайрын гүүр, замын засвар		15,000,000	2,830	12,170.0	15,000.0
5	МХГ-ын автомашины зогсоол		6,723,000	6,723		6,723.0
	Өмнөх онд дутуу олгосон дүн		56,776,812	21,553	12,170.0	33,723.0
	Нийт дүн		512,557,431.0	341,553.0	224,078.5	565,631.5

Тайлант онд хэрэгжүүлэх авто зам, автомашины зогсоол, гүүрийн байгууламжид засвар, арчлалт, өргөтгөл, шинэчлэлт хийх, мөн гэрлэн дохио, хяналтын камерын 2014-

2016 оны цахилгааны төлбөр барагдуулах, ОНХСанд мөнгө хуваарилах, албан журмын даатгалын төлбөр шилжүүлэх зэрэг 2016 онд гүйцэтгэх ажлын жагсаалтыг гаргаж, ИТХТэргүүлэгчдийн тогтоолоор батлуулж, гүйцэтгэсэн байна. Тухайлбал: Номгон ахлах сургуулийн өмнө 150 м урт, 7 м өргөн бетонон автозамыг шинээр барьсан, Загийн гол, Эрдэнэцогтын хүрэмтийн модон гүүрний засвар хийсэн, аймгийн төвийн зарим автозамын зорчих хэсэгт тэмдэг, тэмдэглэгээ хийсэн, Хот хоорондын зорчигч тээврийн газар, Эрдэнэмандал ахлах сургууль, 19, 25-р байр, ХААН банк, ҮЭ, Анар дэлгүүр, Мазаалай болон 13-р цэцэрлэг/хуучин төрийн банк/-ийн автомашины бетонон зогсоолыг шинээр хийсэн, хотын төвийн зарим автозамын гэрэлтүүлгийг сайжруулж, шинэчилсэн, гэрлэн дохио, хяналтын камерын 2014-2016 оны цахилгааны төлбөрийг төлсөн, зарим автозамын нөхөөс, сайжруулалт хийсэн, Эрдэнэмандал хайрханы баруун талаарх автозамыг автогрейдрээр хусаж, тэгшлэх, мөн Эрдэнэмандал хайрханыг тойруулж үерийн болон автомашины замын хаалт шуудуу далан татсан, 2016 оны 7, 8-р саруудад болсон усны үерээс үүссэн 1,2,3,4,5,6,7,9-р багийн нутаг дэвсгэр дэх хөрсөн замууд болон хатуу хучилттай автозам дээр овоорсон элс, хайргыг түрж, зайлуулан ачих, тэгшлэж, нягтруулах, үерийн уснаас шалтгаалж эвдэрсэн хатуу хучилттай автозамын нөхөөсний ажлыг гүйцэтгэх, Төв захын арын автозамыг өргөтгөх, зүүн талын талбайг бетондох, 2, 7-р багийн 2,7 км автозамын ажлын инженерийн нарийвчилсан зураг, төслийг хийлгэсэн, ОНХСанд хуваарилсан мөнгө болон албан журмын даатгалын төлбөрийг шилжүүлсэн байна.

Харин өмнөх онд хийгдсэн ажлын дутуу санхүүжилтийг олгохоор ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар баталсан боловч аймгийн ЗДТГ-ын дэргэдэх автомашины зогсоолын 1200,0 мянга, МХГ-ын автомашины зогсоолын 6723,0 мянган төгрөгийг олгоогүй байна. Энэ нь гүйцэтгэгч компаниуд дутуу ажлаа дуусгаагүй байгаа тул санхүүжилтийг олгоогүй гэсэн тайлбарыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн А.Дорж өгсөн болно.

Б.2 Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл арга, хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг мэргэжлийн байгууллага, хүмүүсээр хийлгээгүй байна.

Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл арга, хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг Сангийн сайд, дэд бүтцийн хөгжлийн сайдын 2000 оны 47/61 тоот тушаалаар батлагдсан журмын 3.3 “Хайгуул, зураг, төсөл, төсвийг **мэргэжлийн байгууллага, хүмүүс тооцож**, аймаг хотын засаг даргаар баталгаажуулна” гэж заасан байна. Гэтэл замын сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөрийн захиалагч нь аймгийн ЗДТГазар

байхад төсвийг мэргэжлийн байгууллага, хүмүүсээр гүйцэтгүүлээгүй, ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн А.Дорж гүйцэтгэж, мэргэжлийн төсөвчин Д.Магвансүрэн хянан баталгаажуулсан байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1."Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалттай зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл өөрийн хийсэн төсөвт ажлыг өөрөө хянаж, хүлээж авч байгаа нь зөрчил үүсгэж байна.

Гүйцэтгэгч компаниуд нь А.Дорж, Д.Магвансүрэн нарын хийсэн зураг, төсвийн дагуу ажлыг гүйцэтгэж, санхүүжилтээ бүрэн авсан байна. Зарим компанийн төсөвт батлагдсан, магадлашгүй ажлын зардал, захиалагчийн хяналтын зардал, ТЭЗҮ болон зураг төсвийн үнэ, нормчлолын сангийн мөнгөний тооцоог дутуу хийж, санхүүжилттэй нь хамт гүйцэтгэгчид шилжүүлсэн байна. Тухайлбал: Эс Жи Эм ХХК-д 371.3, мянга, Хот тохижилт ОНӨҮГ-т 138,6 мянга, Их Богд ХХК-д 1304.7 мянга, Нүнжигт инженеринг ХХК-д 372,0 мянга, Загийн орд ХХК-д 16.8 мянган төгрөгийг суутгаж тооцолгүй, санхүүжилтийг илүү олгосон тул төлбөрийн акт тогтоов.

Б.3 Автозамын сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг үндэслэлгүй нэмэх болон санхүүжих дүнд өөрчлөлт оруулаагүй, төсөл, арга хэмжээний нэр, эхлэх дуусах хугацаа, байршлыг өөрчлөөгүй байна.

Аймгийн ИТХ-ыг Тэргүүлэгчдийн 2016 оны 4-р сарын 4-ны 25-р тогтоолоор батлагдсан замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын жагсаалтад орсон ХААН банк, ҮЭ-ийн өмнөх талбайн төсвийг 10,0 сая төгрөгөөр баталсан боловч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 6-р сарын 10-ны 47-р тогтоолоор ҮЭ-ийн өмнөх талбайг салгаж, 9,0 сая төгрөгөөр, хандиваар баригдсан цэцэрлэгийн гаднах талбайн төсвийг 4,0 сая төгрөгөөр тус тус нэмж баталсан байна.

Дээрхи өөрчлөлт нь ХААН банк, ҮЭ-ийн өмнөх талбайн ажлын төсөвт зардлын тооцоо хийгдээгүй байхад ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар 10,0 сая төгрөгөөр баримжаалж, жагсаалтад оруулснаас төсвийг шинээр хийж ҮЭ-ийн өмнөх болон Анар дэлгүүрийн өмнөх талбайн зардлыг нэмэгдүүлжээ. Хандивын цэцэрлэгийн гаднах талбай нь байгалийн төрхөөрөө байсан газар дээр хийгдэх ажил учраас төсөвт өртгийг нь 4,0 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

В.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг журмын дагуу зохион байгуулж байгаа боловч зориулалтын машин, техник, тоног төхөөрөмж хангалтгүй зарим компанийг шалгаруулж, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12-р зүйлийг зөрчжээ.

В.1 Үнэлгээний хороог журмын дагуу зохион байгуулж, худалдан авах ажиллагааны аргыг зөв сонгож, ил тод, шуурхай байдлыг хангаж ажилласан байна.

Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлын үнэлгээний хороог журмын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар төсөл, хөтөлбөр, ажил бүр дээр гаргаж, нээлттэй, ил тод, шуурхай байдлыг ханган ажиллажээ.

Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх 15 ажлын тендерийг явуулахдаа 9 ажлыг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, 6 ажилд шууд гэрээ байгуулсан байна.Үүнд:

1.Хот хоорондын болон орон нутгийн зорчигч тээврийн гаднах 1250м2 автомашины зогсоолын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2016 оны 4-р сарын 25-ны 262-р захирамжаар байгуулж, харьцуулалтын аргаар тендер шалгаруулах журмаар цахимаар зарлаж, Наран тээг компани ХХК шалгарсан байна.

2.Хотын төвийн авто замын гэрэлтүүлгийг 100вт-ын LED гэрэлтүүлгээр солих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2016 оны 5-р сарын 23-ны 326-р захирамжаар байгуулж, харьцуулалтын аргаар тендер шалгаруулах журмаар цахимаар зарлахад нэг ч компани саналаа ирүүлээгүй байна. Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33-р зүйлийн 33.4-т заасны дагуу шууд гэрээ байгуулан тухайн ажлыг гүйцэтгүүлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна. Ингээд Баянхонгор сумын “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ-аар 2016 оны 6-р сарын 3-аас 6-р сарын 29-ны хооронд 17,2 сая төгрөгөөр гүйцэтгүүлэх шууд гэрээ байгуулжээ.

3.Аймгийн төвийн авто замын зорчих хэсэгт хэвтээ тэмдэглэгээ 500м2, 25 ширхэг тэмдгийг 14.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2016 оны 4-р с арын 25-ны 259-р захирамжаар байгуулсан байна. Дээрхи ажлын тендерт 4 компани материал ирүүлснээс Элбата ХХК-ийг шалгаруулжээ. Элбата ХХК нь уг ажлыг 2016 оны 6-р сарын 8-аас 6-р сарын 22-ны хооронд гүйцэтгэх гэрээ байгуулжээ.

4. Эрдэнэмандал ахлах сургуулийн гаднах автомашины зогсоолын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2016 оны 4-р сарын 25-ны 257-р захирамжаар байгуулж, харьцуулалтын аргаар тендер шалгаруулах журмаар цахимаар зарлаж, Эс Эм Жи, Елбата гэсэн 2 компани материал ирүүлснээс Эс Эм Жи ХХК 19,9 сая төгрөгийн үнийн санал ирүүлж шалгарсан байна.

5. Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын засвар арчлалтаар 2016 онд 1270м² талбайд нөхөөс, 2 автобусны зогсоолын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах цахим тендерт материал ирүүлээгүй тул “Их богд зам” ХХК-тай шууд гэрээ байгуулжээ

6. Баянхонгор сумын 19,25 дугаар байрны гаднах 1520 м² авто машины зогсоол болон авто замын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2016 оны 4- сарын 25-ны 260-р захирамжаар байгуулж, тендерийг харьцуулалтын аргаар, цахим хэлбэрээр шалгаруулахаар зарласан байна. Их Богд зам ХХК, Элбата ХХК гэсэн 2 компани уг ажлыг гүйцэтгэх тендерийн материал ирүүлснээс Элбата ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулжээ.

7. 2,7 дугаар багийн нутаг дэвсгэр дэхь сайжруулсан хөрсөн замын 100000м² талбайд хусалт хийх, 720м³ хуучин шуудуу сэргээх ажлыг “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ 2016 оны 6 дугаар сарын 5-наас 06 сарын 25-ны хооронд 7.4 сая төгрөгийн өртөгтэйгөөр шууд гэрээгээр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан байна.

8. ХААН банкны гаднах 750м² авто зогсоолыг 10,0 сая төгрөгөөр “Наран тээг” ХХК-иар 2016 оны 06 дугаар сарын 25-наас 2015 оны 09 дүгээр сарын 20-нд гүйцэтгүүлэхээр шууд гэрээ байгуулсан.

9. Үйлдвэрчний эвлэлийн гаднах 650м² талбайг 9 сая төгрөгөөр “Наран тээг” ХХК 2016 оны 07 дугаар сарын 10-ны хугацаанд хийж гүйцэтгэхээр шууд гэрээ байгуулсан.

10. Анар дэлгүүрийн гаднах 170 м² зам талбайг 5 сая төгрөгөөр “Наран тээг” ХХК 2016 оны 07 сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэхээр шууд гэрээ байгуулсан.

11. Номундалай сургуулийн өмнөх 150м автозамын тендерийн үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2016 оны 5-р сарын 23-ны 324 тоот захирамжаар байгуулж, цахимаар 40,0 сая төгрөгийн үнийн дүн бүхий тендер шалгаруулалт явуулж, “Галхонгор” ХХК компани 39,8 сая төгрөгийн үнийн саналтай материал ирүүлсэн байна. Өөр компани материал ирүүлээгүй тул “Галхонгор” ХХК шалгарсан байна.

12. Төв захын арын замын өргөтгөл болон зах доторх авто машины зогсоол, бильярдын тоглоомын нийт 1850м² зам, талбайн ажлыг гүйцэтгүүлэх ажлын үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2016 оны 5-р сарын 23-ны 328-р захирамжаар байгуулж, харьцуулалтын аргаар цахим тендер зарласан боловч нэг ч компани санал ирүүлээгүй байна. Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33-р зүйлийн 33.4-т заасны дагуу шууд гэрээ байгуулан тухайн ажлыг гүйцэтгүүлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна. Иймээс 66,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй уг ажлыг 2016 оны 6-р сарын 17-оос 6-р сарын 30-ны хооронд “Их богд зам” ХХК-аар гүйцэтгүүлэх шууд гэрээ байгуулжээ.

13. Хандиваар баригдсан “Мазаалай” цэцэрлэгийн гаднах авто зогсоол болон замын 530м² талбайн ажлыг 9,9 сая төгрөгөөр гүйцэтгэх төсвийг аймгийн ИТХТ-ийн 2016 оны 5-р сарын 20-ны 43-р тогтоолоор баталсан бөгөөд “Нүнжигт инженерн” ХХК 2016 оны 06 дүгээр сарын 20-ноос 2016 оны 6 дүгээр сарын 24-ны хугацаанд гүйцэтгэх шууд гэрээ байгуулжээ.

14. 13-р цэцэрлэг/төрийн банкны/-ийн гаднах талбайн автозогсоолын ажлыг Алтайн гурван нуур ХХК-иар 2016 оны 6-р сарын 8-аас 6-р сарын 11-ний хооронд 9,7 сая төгрөгөөр гүйцэтгүүлэх шууд гэрээ байгуулсан байна.

15. Баянхонгор сумын 1,2,3,7,9 дүгээр багийн нутаг дэвсгэр дэхь хатуу хучилттай болон хөрсөн замын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2016 оны 10-р сарын 5-ны А/617-р захирамжаар байгуулсан байна. Тендерийг 2016 оны 10-р сарын 7-оос 10-р сарын 14-ний хооронд зарласан боловч 1 ч компани материал ирүүлээгүй тул дээрх ажлыг “Их богд зам” ХХК-иар гүйцэтгүүлэх гэрээ байгуулжээ.

В.2 Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа зориулалтын машин, техник, тоног төхөөрөмж хангалтгүй зарим компани шалгаруулж, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12-р зүйлийг зөрчсөн байна.

Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12-р зүйлийн 12.2 “Захиалагч тухайн тендер шалгаруулалтад тавигдах чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд нийцүүлэн тогтоож, тендерийн баримт бичигт тусгана”, 12.4.”Захиалагч «хамгийн сайн»

үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоос өмнө энэ хуулийн 12.2-т заасан чадавхын шаардлагыг хангаж байгаа эсэхийг дахин магадалж болно” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйгээс шалгарсан зарим компаниуд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй байдал үүссэн байна. Тухайлбал:

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хуулийн дагуу зохион байгуулагдсан хэдий ч Замын зорчих хэсгийн тэмдэг, тэмдэглэгээ хийх ажилд шалгарсан Элбата ХХК нь замын тэмдэг, тэмдэглэгээ хийх зориулалтын тоног төхөөрөмжгүй байснаас гэрээг цуцалж, тухайн ажлыг Их Богд зам ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын акт үйлдэж, ашиглалтад хүлээн авчээ.

Мөн 2,7 дугаар багийн нутаг дэвсгэр дэх сайжруулсан хөрсөн замын 100000 м2 талбайд хусалт хийх, 720м3 хуучин шуудуу сэргээх ажлыг “Хот тохижилт үйлчилгээ”ОНӨҮГ 2016 оны 6 дугаар сарын 5-наас 06 сарын 25-ны хооронд 7.4 сая төгрөгийн өртөгтэйгөөр шууд гэрээгээр гүйцэтгэхээр гэрээ байгуулжээ. Гэвч Хот тохижилт нь замын техник тоног төхөөрөмж авахаар төлөвлөсөн ажил нь хэрэгжээгүй тул, Их Богд ХХК-иар гүйцэтгүүлсэн байна.

Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын тендерт шалгарсан бусад компаниуд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэжээ.

Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэхээр төлөвлөж, батлагдсан төсөл арга, хэмжээнээс 20,0 сая төгрөгийн өртөгтэй явган замын засварын ажлыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 10-р сарын 9-ний 97-р тогтоолоор хассан шийдвэрээс өөр өөрчлөлт ороогүй байна.

В.3 Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын худалдан авах ажиллагаанаас бий болсон хэмнэлтийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, үр ашиггүй зүйлд зарцуулаагүй байна.

Замын санд батлагдсан төсвийн тендерийн хэмнэлтийг зориулалт бус зарцуулаагүй байна.

Г. Баянхонгор сумын 2,3,7,9-р багийн хатуу хучилттай болон хөрсөн замд үерийн улмаас үүссэн эвдрэл гэмтлийг засварлах ажил дуусаагүй, харин бусад замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлын хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт нь үр нөлөөгөө өгсөн байна.

Г.1 Гүйцэтгэгч компаниуд гэрээнд заасан ажлыг техникийн шаардлагын дагуу заасан хугацаандаа бүрэн гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн байна.

❖ Хот хоорондын болон орон нутгийн зорчигч тээврийн гаднах 1250м² автомашины зогсоолын тендерт шалгарсан Наран тээх ХХК нь ажлыг 2016 оны 5 дугаар сарын 26-аас 6 дугаар сарын 15-ны хугацаанд 13,4 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж, 2016.6.07-нд техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.



❖ Хотын төвийн авто замын гэрэлтүүлгийг 100вт-ын LED гэрэлтүүлгээр солих ажлын гүйцэтгэгч “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ нь гэрээнд зааснаар БТСАЖГ-ын дэргэдэх автозамын уулзвараас Баянхонгор сумын 2-р байрны баруун урд хүртэлх, Татварын хэлтсийн баруун урд уулзвараас зүүн тийш Байдраг төвийн зүүн урд уулзвар, МХГ-ын баруун уулзвараас Солонго бичиг хэргийн дэлгүүрийн зүүн хойд уулзвар, Хонгор хотхоны баруун урд уулзвараас Баянхонгор зочид буудлын зүүн хойд уулзвар, ЭМГазрын уулзвараас 3, 6-р багийн дундуур явсан автозам, Аюулгүйн тойргоос зүүн тийш 45-р байр хүртэлх автозам, аюулгүйн тойргоос 5, 6-р багийн дундуур явсан автозам, ОБХэлтсийн уулзвараас Нисэх буудал хүртэлх автозам, Есөн-Эрдэнэ захын уулзвараас Баруун бүсийн уулзвар хүртэлх автозам, Нэгдсэн эмнэлгийн зүүн хойд уулзвараас зүүн тийш Аюулгүй тойрог хүртэлх автозамын гэрэлтүүлгийг засварлах, шинэчлэх ажлуудыг бүрэн гүйцэтгэж, 2016 оны 7-р сарын 6-ны өдөр ажил хүлээлцэх акт үйлдэн хүлээлгэн өгсөн байна.



❖ Аймгийн төвийн авто замын зорчих хэсэгт хэвтээ тэмдэглэгээ 500м², 25 ширхэг тэмдгийг 14.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Элбата ХХК уг ажлыг 2016 оны 6-р сарын 8-аас 6-р сарын 22-ны хооронд гүйцэтгэх гэрээ байгуулсан боловч тус компани нь замын тэмдэг, тэмдэглээ хийх зориулалтын тоног төхөөрөмжгүйгээс гэрээг цуцалж, 2016 оны 7-р сарын 4-ний өдөр “Их богд зам” ХХК компанитай дахин гэрээ байгуулжээ. Их Богд зам компани нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, ажлаа хугацаанд нь хүлээлгэн өгсөн байна.



❖ Эрдэнэмандал ахлах сургуулийн гаднах 800м² зогсоолын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Эс Эм Жи ХХК нь 19,9 сая төгрөгийн өртөг бүхий уг ажлыг 2016 оны 5-р сарын 23-аас 6-р сарын 14-ний хооронд гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж, 2016 оны 8-р сарын 9-нд техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.



❖ Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын засвар арчлалтаар 2016 онд 1270м² талбайд нөхөөс, 2 автобусны зогсоолын ажлын гүйцэтгэгч “Их богд зам” ХХК нь дээрх ажлыг 2016 оны 6-р сарын 8-аас 6-р сарын 27-ны хооронд 68.1 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.



❖ Баянхонгор сумын 19,25 дугаар байрны гаднах 1520 м² авто машины зогсоол болон авто замын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Элбата ХХК нь дээрх ажлыг 2016 оны 5-р сарын 25-аас 6-р сарын 17-ны хооронд 33,0 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулжээ. Тендерт заагдсан ажлыг бүрэн гүйцэтгэж, 2016 оны 6-р сарын 7-ны өдөр хүлээлгэн өгсөн байна.



❖ 2,7 дугаар багийн нутаг дэвсгэр дэх сайжруулсан хөрсөн замын 100000м² талбайд хусалт хийх, 720м³ хуучин шуудуу сэргээх ажлын гэрээ байгуулсан “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ нь замын техник тоног төхөөрөмж авахаар төлөвлөсөн ажил нь хэрэгжээгүй тул Их Богд ХХК-иар гүйцэтгүүлсэн байна. Ажлын гүйцэтгэлийн явцад аймгийн Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн А.Дорж, Хот тохижилтын мэргэжилтнүүд хяналт тавьж ажиллажээ.



❖ ХААН банкны гаднах 750м² авто зогсоолыг “Наран тээг” ХХК 10.0 сая төгрөгөөр 2016 оны 06 дугаар сарын 25-наас 2015 оны 09 дүгээр сарын 20-нд шууд гэрээгээр гүйцэтгэн хүлээлгэн өгсөн байна.



❖ Үйлдвэрчний эвлэлийн гаднах 650м² талбайг 9 сая төгрөгөөр “Наран тээг” ХХК шууд гэрээгээр 2016 оны 07 дугаар сарын 10-ны хугацаанд хийж гүйцэтгэсэн.



❖ Анар дэлгүүрийн гаднах 170 м² зам талбайг 5 сая төгрөгөөр “Наран тээг” ХХК шууд гэрээгээр 2016 оны 07 сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэсэн.



❖ Номундалай сургуулийн өмнөх 150м автозамын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Гал хонгор” ХХК нь нь дээрх ажлыг зураг төсвийн дагуу, 2016 оны 07 дүгээр сарын 05-наас 07 дугаар сарын 20-ны хугацаанд гүйцэтгэх гэрээ байгуулж, 2016 оны 8-р сарын 1-нд техникийн комисс-т хүлээлгэн өгсөн байна.



❖ Төв захын арын замын өргөтгөл болон зах доторхи авто машины зогсоол, бильярдын тоглоомын нийт 1850м² зам, талбайн 66,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2016 оны 6-р сарын 17-оос 6-р сарын 30-ны хооронд гүйцэтгэхээр шууд гэрээ байгуулсан “Их богд зам” ХХК нь дээрх ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, 2016 оны 07 дугаар сарын 9-нд техникийн комисс-т хүлээлгэн өгсөн байна.



❖ Хандиваар баригдсан “Мазаалай” цэцэрлэгийн гаднах авто зогсоол болон замын 530м² талбайн ажлыг 9,9 сая төгрөгөөр 2016 оны 06 дугаар сарын 20-ноос 2016 оны 6 дүгээр сарын 24-ны гүйцэтгэхээр “Нүнжигт инженерн” ХХК шууд гэрээ байгуулсан боловч аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 10-р сарын 9-ний 97-р тогтоолоор дээрх ажлын төсвийг 4,0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталж гүйцэтгүүлжээ. Уг ажлыг

2016 оны 8-р сарын 03-ны өдөр техникийн комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна.



❖ 13-р цэцэрлэг/төрийн банкны/-ийн гаднах талбайн автозогсоолын ажлын гүйцэтгэгч Алтайн гурван нуур ХХК уг ажлыг 2016 оны 6-р сарын 8-аас 6-р сарын 11-ний хооронд 9,7 сая төгрөгөөр гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, хугацаандаа гүйцэтгэн хүлээлгэж өгсөн байна.

❖ Баянхонгор сумын 1,2,3,7,9 дүгээр багийн нутаг дэвсгэр дэх хатуу хучилттай болон хөрсөн замын засварын ажлын гүйцэтгэгч “Их богд зам” ХХК-тай байгуулсан гэрээнд 1,2,3,4,5,6,7,9-р багийн нутаг дэвсгэр дэх хөрсөн замууд болон хатуу хучилттай автозам дээр овоорсон элс, хайргыг түрж, зайлуулан ачих, тэгшлэх, нягтруулах, үерийн уснаас шалтгаалж эвдэрсэн хатуу хучилттай автозамын нөхөөсний ажил /Улсын чиглэлийн төв замаас Эх булаг шатахуун түгээх станцын уулзвар, Эх булаг ШТС-ын уулзвараас Солонго дэлгүүр, МХГ-аас Хонгор хотхон, Хонгор хотхоноос Хотын захиргааны уулзвар, Петровис ШТС-4-өөс аюулгүйн тойрог, 3, 6-р багийн дундуур Хаус хороолол, Нэгдэлчин зочид буудлын уулзвараас Төв захын араар Магнай трейд ШТС хүртэл, Дунд захаас Төв зах хүртэлх нийт 180м2 талбайд нөхөөс, засвар хийхээр тусгасан байна. Дээрх ажлыг “Их богд зам” ХХК 26,9 сая төгрөгийн төсөвт өртгөөр гүйцэтгэж, 10-р сард багтаан ашиглалтад хүлээлгэн өгөх гэрээ байгуулсан боловч гэрээнд заасан ажлаа хугацаанд бүрэн гүйцэтгээгүй тул санхүүжилтийг дутуу олгож, дутуу орхисон хатуу хучилттай автозамын засварын ажлыг 2017 онд гүйцээж хийх болсон байна.



16.Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэхээр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлагдсан гэрлэн дохио хяналтын камерын 2015-2016 оны цахилгааны төлбөрт 4564,0 мянга, Өлзийтийн Цагаан хөтлийн хяналтын камерын 2014-2016 оны цахилгааны төлбөрт 3454,5 мянга, автозамын хяналтын зардалд 10461,1 мянга, 2, 7-р багийн дундуур явсан 2,7 км автозамын ажлын инженерийн нарийвчилсан зураг төсөлд 13000,0 мянга, ОНХСанд 60,0 сая, Албан журмын даатгалд 28,5 сая төгрөг тус тус шилжүүлсэн байна.

Г.2 Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлуудаас гэрээнд заасан ажлаа дутуу гүйцэтгэсэн Их Богд зам ХХК-ний Баянхонгор сумын 1,2,3,7,9 дүгээр багийн нутаг дэвсгэр дэх хатуу хучилттай болон хөрсөн замын засварын ажлаас бусад бүрэн хийгдсэн ажлуудын санхүүжилтийг олгосон байна.

2016 онд замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлуудаас Их Богд ХХК-ий гүйцэтгэсэн 10,0 мянгатын голын замын болон хатуу хучилттай автозамын засварын нөхөөс хийх ажил дуусаагүй тул санхүүжилтийг 5,6 сая төгрөгөөр дутуу олгожээ.

Дээрх ажлаас бусад бүх ажлыг бүрэн гүйцэтгүүлж, техникийн комисс хүлээн авсан тул санхүүжилтийг бүрэн олгожээ.

Г.3 Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих талуудын хяналт хангалттай, захиалагч гэрээ дүгнэж хэрэгжилтийг хангуулсан байна.

Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажилд тавих шат шатны хяналтын үүргийг Сангийн сайд, дэд бүтцийн сайдын 2000 оны 47/61 тушаалаар батлагдсан журмын 4.5 дахь заалтын дагуу захиалагч талын төлөөлөл, аймгийн ЗДТГ-ын болон сумын ЗДТГ-ын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн, МХГ-ын авто зам, тээвэр хариуцсан улсын байцаагч болон холбогдох эзэмшигч байгууллагын удирдлагууд тухай бүр нь гүйцэтгэж, хэрэгжилтийг хангуулсан байна.

Г.4 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үр ашиг хангалттай, чанарын болон ашиглалтын шаардлага хангасан байна.

2016 онд замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлуудаас 10,0 мянгатын голын зам, төв захын арын асфальтан замын засвараас бусад ажлууд бүрэн хийгдэж, гэрээний хэрэгжилт хангалттай, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр үр нөлөөтэй байна.

Аудитаар нийт 269.1 сая төгрөгийн зөрчил илэрч 2.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон 266.9 сая төгрөгийн зөвлөмж өгөв.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Гүйцэтгэлийн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

1. АТБӨЯХ-ийн албан татвар болон замын хураамжийн орлогыг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

2. Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөлтийг үндэслэлтэй боловсруулсан хэдий ч Засгийн газрын 1998 оны 149-р тогтоолоор батлагдсан журмын 8 дахь заалтыг зөрчин аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын **Тэргүүлэгчдийн хурлаар** баталгаажуулсан нь 2015 онд аймгийн Аудитын газраас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3. Замын сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг нэгдсэн бодлого, төлөвлөлтийн арга зүй, урт болон дунд хугацааны хөтөлбөрт үндэслэж төлөвлөсөн байна.

4. Замын сангийн хөрөнгөөр аймгийн төвийн төв замын болон Өлзийт сумын цагаан хөтлийн замын хяналтын камерийн цахилгааны зардал /**урсгал зардал**/-ыг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 4.1.7, Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан "авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"-ын 4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

5. Засгийн газрын 2014 оны 184 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг зөрчин Замын сангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэн, комисс хүлээн авсан албан газар, орон сууцны гаднах авто зогсоолуудын ажлыг орлого авч, хөрөнгөнд бүртгээгүй нь зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар илэрч 235.2 сая төгрөгийн хөрөнгийг орлого авахуулах албан шаардлагыг хүргүүлсэн байна.

6. Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12-р зүйлийн 12.2, 12.4 дэх заалтуудыг хэрэгжүүлээгүйгээс шалгарсан зарим компаниуд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байгаа нь тендерийн үнэлгээний хороо зарим шалгаруулалтыг хангалтгүй гүйцэтгэсэн байгааг харуулж байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

2017.06.06

Баянхонгор хот

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Замын сангийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга, хэмжээний хуваарилалт, зарцуулалт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн доорх албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна.

НЭГ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.БАТЖАРГАЛД

1. Тендерийн үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн тендерт оролцогчийн чадварын үнэлэх тухай 12 дугаар зүйл болон 14-16 дугаар зүйлийн заалтыг хэрэгжүүлж, тендер шалгаруулалт явуулахдаа тендерт материалаа ирүүлсэн компани нь тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах зориулалтын тоног төхөөрөмжтэй эсэх, мэргэжлийн ажилчидтай эсэхийг нягтлан, дүгнэлт гаргаж, шалгаруулж байх.

2. Авто замын санд төвлөрөх авто болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлого болон авто зам ашигласны хураамжийг аймгийн Авто тээврийн газарт бүртгэлтэй автомашины судалгаанд үндэслэн бодитой төлөвлөж, холбогдох байгууллагуудтай хамтарч төлөвлөсөн орлогыг бүрэн бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

3. Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын жагсаалт, төсвийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн батлуулж байх.

4. Замын сангийн хөрөнгийг төлөвлөж, зарцуулахдаа урсгал зардлыг санхүүжүүлдэг байдлыг зогсоож, замын хяналтын камертай холбоотой урсгал зардлыг эзэмшигч байгууллагын тайлант жилийн төсөвт баталж, зарцуулж байх.

ГУРАВ. ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАРТ

4. ХААН банк, Үйлдвэрчний эвлэл, Анар дэлгүүрийн өмнөх болон 13-р цэцэрлэг, 5-р цэцэрлэг/хуучин төрийн банк/-ийн дэргэдэх автомашины зогсоол, талбайг тухайн албан газар, байгууллагуудад эзэмшүүлж, цаашдын засвар үйлчилгээний ажлыг хариуцуулах талаар эрх бүхий байгууллагад асуудал оруулж шийдвэрлүүлэх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

